



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Бүртгэл, зөвшөөрлийг шуурхай шийдвэрлэх
талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 8 дугаар зүйлийн 8.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4, 4.2.12, 4.4.4, 4.7.10, 4.8.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны багц дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.12, 6.20, 6.24, 6.34, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.8 дахь заалтад заасныг Санхүүгийн зохицуулах хорооны даргад төлөөлөн шийдвэрлэх эрхийг олгосугай.

2. Энэ тогтоолыг 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН